



ДOTOOD ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН - 2020

ТОВХИМОЛ



ДOTOOD ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН - 2020

(ТОВХИМОЛ)

Нэгтгэж боловсруулсан:

Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн
Шинжлэн магадлахуй судлалын төвийн эрдэм
шинжилгээний ажилтан, цагдаагийн дэд хурандаа
О.Одонтуяа

Хянасан:

Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал,
доктор (Ph.D), цагдаагийн хурандаа **Т.Очирбат**

Эх бэлтгэсэн:

Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн
Хэвлэл, редакцийн хэлтсийн эх бэлтгэгч-дизайнер,
цагдаагийн дэд ахлагч **Б.Жамсран**

Огноо

2021 оны 01 дүгээр сарын 15
Дотоод хэргийн их сургуулийн Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	5
ТОВЧИЛСОН ҮГ	7
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	8
Эрдмийн зөвлөл	9
Эрдмийн дэд зөвлөл	11
Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл	11
Профессорын судалгааны баг	13
Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн	15
СУДАЛГАА-БОЛОВСРУУЛАЛТЫН ХҮНИЙ НӨӨЦ	20
СУДАЛГАА-БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ	21
Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй төсөл, хэрэгжилт	21
Захиалгат болон төлөвлөгөөт судалгаа-боловсруулалтын ажил	24
Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн судалгааны ажил, эрдэм шинжилгээний хурал, ажлын орчин нөхцөл, техник хэрэгслийн санхүүжилт	33
Инновацийн чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр	35
Оюуны өмч	36
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ	36
Профессор, багшийн оролцсон эрдэм шинжилгээний цахим хурал	36
Сонсогчдын оролцсон эрдэм шинжилгээний цахим хурал	40
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, УУЛЗАЛТ	
ОНОЛЫН БОЛОН АРГА ЗҮЙН СЕМИНАР	42
Эрдэм шинжилгээний хурал	42
Оюутны эрдэм шинжилгээний хурал	44
Онол, арга зүйн семинар, дугуй ширээний уулзалт, хэлэлцүүлэг	45
Хичээл, сургалт	47
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛ	48
Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн	48
Хууль сахиулахын удирдлагын академи	50
Ахисан шатны боловсролын сургууль	52

Цагдаагийн сургууль.....	523
Хилийн албаны сургууль.....	57
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль	59
Онцгой байдлын сургууль	60
Эрх зүй, нийгмийн ухааны сургууль	61
Ахлагчийн сургууль	63
Шинжлэн магадлахуйн институт.....	64
Гадаад хэлний институт.....	64
Сургалтын бодлого, төлөвлөлтийн газар	66
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН СУРТАЛЧИЛГАА	66
ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР	70
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ	71
КЛУБ, ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	71
ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	72
НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	73
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН.....	75

ӨМНӨХ ҮГ

Дотоод хэргийн их сургуулийн эрдмийн хамт олон бид 2020 онд судалгааны тэргүүлэх чиглэл, тулгамдсан асуудлуудад нөөцийг төвлөрүүлэх, инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын менежментийг сайжруулах замаар эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх зорилт дэвшүүлсэн билээ.

Их сургуулийн шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн “Докторын хөтөлбөрт өдрөөр суралцагч элсүүлэх журам”-ыг батлуулав. Энэ журмын дагуу агентлаг, байгууллагаас 7 албан хаагч докторантурт элсэн суралцаж, эрдэм шинжилгээний ажил эрхэлж байна. Түүнчлэн, Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн бүтцэд Аюулгүй байдал судлалын төв, Хууль сахиулахуйн боловсрол судлалын төв, Судлаачийн хөгжлийн төвийг шинээр байгууллаа.

2020 онд Их сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан, профессор багш нар аюулгүй байдлыг хангах, хууль зүй, дотоод хэргийн салбарын тулгамдсан асуудлаар 75 судалгааны ажил гүйцэтгэн, эрдэм шинжилгээний 87 өгүүлэл хэвлүүлж, 53 илтгэл хэлэлцүүлэн, 9 сурах бичиг, 50 гарын авлага, нэг сэдэвт бүтээл туурвисан байна.

Уламжлал болгон зохион байгуулж ирсэн олон улсын эрдэм шинжилгээний хурлыг “Олон улсын хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй тулгамдаж буй асуудал” сэдвийн дор амжилттай зохион байгууллаа. Түүнчлэн, улсын, салбарын, Их сургуулийн хэмжээний эрдэм шинжилгээний 16 хурал зохион байгуулснаас гадна ОХУ болон БНСУ-ын их, дээд сургуулиудаас зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал, арга хэмжээнд профессор багш, сонсогч нар идэвхтэй оролцов.

Инновацийн төсөл, бүтээлийн уралдааныг тав дахь жилдээ уламжлал болгон зохион байгууллаа. Энэ жилийн уралдаанд оролцсон бүтээлүүд Их сургуулийн үйл ажиллагаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн шинэ санаа, шинэ мэдлэгийн бий болгох зорилго агуулснаараа онцлог байв.

Эрдмийн зөвлөл, Эрдмийн дэд зөвлөл, Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл, Шинжлэх ухаан, технологийн зөвлөл, Редакцийн зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, тодорхой асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв. Их сургуулийн хэмжээнд 18 чиглэлийн профессорын судалгааны баг ажиллан нийт 52 удаа хуралдаж, магистрант, докторантуудын судалгааны ажлын сэдэв, профессор багш, судлаачдын туурвисан ном бүтээлийг хэлэлцэж, зохих зөвлөмж, шийдвэрүүдийг гаргасан. Их сургуулийн “Эмерит профессор” өргөмжит цол бий болгож, уг цолыг Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор,

хошууч генерал Б.Пүрэв, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор, профессор, дэслэгч генерал Ш.Арвай, Монгол Улсын гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор, бэлтгэл хурандаа А.Лхагваа нарт олгохоор шийдвэрлэсэн нь цаашид хууль зүй, дотоод хэргийн салбарт бий болсон шинжлэх ухааны дэг сургуулийг сурталчлан таниулах, үргэлжлүүлэн хөгжүүлэх ач холбогдолтой билээ.

Дотоод хэргийн их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх төсөөлөл боловсруулж, макет хийлгэн, УИХ-ын дарга, Засгийн газрын тэргүүн, бусад холбогдох албан тушаалтнуудад танилцуулан, хотхоны техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулахаар шийдвэрлүүлсэн нь Их сургууль цаашид аюулгүй байдал, дотоод хэргийн салбарын шинжлэх ухаан, технологийн томоохон төв, технополис хотхон болж хөгжих алхам болсон гэж үзэж байна. Монгол Улсын хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” болон бусад холбогдох баримт бичгүүдэд Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацийн чадавхийг сайжруулах, хотхон хэлбэрээр хөгжүүлэх зорилтууд туссан нь уг төсөл хэрэгжих гол үндэслэл болж байгаа билээ. Түүнчлэн, “Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацийн хөгжлийн хөтөлбөр 2021-2024” боловсруулсан.

Мөн 2020 онд эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх таатай орчин бүрдүүлэх, судлаачийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, материаллаг бааз, техник хэрэгслийг сайжруулах чиглэлээр бодитой ажлууд хийж гүйцэтгэснийг цохон тэмдэглэж байна. Үүнд, судалгааны арга зүйн танхим байгуулсан, зарим судлаачийн өрөөний засвар, тохижилтын ажлыг хийж гүйцэтгэснийг дурдаж болно.

Их сургуулийн эрдмийн хамт олон та бүхэндээ ажлын амжилт хүсье.

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,
ДОКТОР (Ph.D), ЦАГДААГИЙН ХУРАНДАА Т.ОЧИРБАТ**

ТОВЧИЛСОН ҮГ

БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БЗД	Баянзүрх дүүрэг
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
НҮБ	Нэгдсэн Үндэсний байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үнэлгээ
УИХ	Улсын Их Хурал
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЭШНХ	Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дотоод хэргийн их сургууль Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.5. “Мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлттэй уялдуулан судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд суурилсан өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог бий болгож, судалгаанд суурилсан үндэсний их сургуулийг хөгжүүлнэ”, 2.4.2. “Шинжлэх ухаан, технологи, инновацийн чиглэлээр шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлж, олон улсын стандартад нийцүүлнэ” зэрэг үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэх, Хууль зүйн сайдын 2016 оны А/119 дугаар тушаалаар баталсан “Хөгжлийн стратеги хөтөлбөр” (2016-2025)-ийг хэрэгжүүлэх зорилгоор “судалгааны тэргүүлэх чиглэл, тулгамдсан асуудлуудад нөөцийг төвлөрүүлэх, инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх, судалгаа-боловсруулалт, туршилт-зохион бүтээх ажлын менежментийг өөрчлөх замаар эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлнэ” гэсэн үйл ажиллагааны зорилт дэвшүүлж, хэрэгжүүллээ.

Дээрх хөгжлийн стратеги зорилтыг хангах ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, Их сургуулийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, биелэлт үр дүнг тухай бүр тооцон ажилласан.

Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг хангах, эрдэм шинжилгээ, судалгаа зэрэг олон талт ажлыг хэрэгжүүлэхдээ Дээд боловсролын тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль зэрэг шинжлэх ухаан, технологийн багц хуулиуд, төрөөс боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийн талаар баримтлах төрийн бодлогод тулгуурлан Их сургуулийн дүрэм, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын журам, Их сургуулийн захирлын 2015 оны А/211 дугаар тушаалаар баталсан “Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандарт”, 2016 оны А/175 дугаар тушаалаар батлагдсан “Судлаач 2025” хөтөлбөрийг баримтлан ажиллав.

Улс орны болон хууль сахиулах салбарын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх төсөл хэрэгжүүлж, хөгжлийн бодлого тодорхойлоход эрдэмтэн, судлаач, багш нарын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, судалгаа-боловсруулалтын ажлын менежментийг өөрчлөх замаар хууль зүйн шинжлэх ухааны онолын судалгааны түвшинг дээшлүүлж, шинэ мэдлэг бий болох үйл явцыг мэргэжлийн удирдлагаар ханган, дэмжих чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ирлээ.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар нэр хүндтэй эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлэх судалгааны өгүүллийн чанарыг

сайжруулан, олон улсын болон хууль сахиулах салбарын эрдэм шинжилгээний хурлуудыг амжилттай зохион байгуулж, судалгааны ажлын чанарыг дээшлүүлэн, судалгаа-боловсруулалтын хүний нөөц, эрдэмтдийн эзлэх хувийг нэмэгдүүлсэн ололт амжилттай ажиллалаа.

Эрдмийн зөвлөл

Их сургуулийн захирлын 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/42 дугаар тушаалаар Эрдмийн зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлав.



Эрдмийн зөвлөлийн 2020 оны анхдугаар хуралдаан 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр болж, гишүүдэд шинээр хүндэтгэлийн өмсгөл, батламж, ажлын цүнх, дэвтэр зэргийг гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулсан. Хуралдаанаар “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулах тухай”, “Өдрийн хэлбэрээр докторын сургалт”-ыг явуулах тухай, “Эрдмийн профессор, дэд профессор” цол олгуулах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргав.

Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Б/201 дүгээр тушаалаар судлаач, доктор (Ph.D), дэд профессор Ч.Нямсүрэнд “Эрдмийн профессор” цол, Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хошууч Б.Энхболд, Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа Н.Мөнхзул, ХХЕГ-ын Хилийн цэргийн төв архивын Түүхийн секторын судлаач, доктор (Ph.D) Н.Даваадорж, Ахисан шатны боловсролын сургуулийн хөтөлбөрийн менежер, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа Д.Булган нарт “Эрдмийн дэд профессор” цол олгов.



Дотоод хэргийн их сургуулийн захирлын 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн Б/336 дугаар тушаалаар 10 хүнд “Дэд профессор” цол олгохоор шийдвэрлэж, батламжийг гардуулав. Үүнд:

1. Их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал бөгөөд Сургалтын бодлого, төлөвлөлтийн газрын дарга, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа Д.Эрдэнэбаатар;

2. Захиргааны удирдлагын газрын дарга, доктор (Ph.D), хурандаа Ш.Чулуунбат;

3. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа О.Зоригт;

4. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгч, доктор (Ph.D) Ж.Оюунтунгалаг;

5. ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд хурандаа Д.Сэржмядаг;

6. Улаанбаатарын их сургуулийн Эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн бэлтгэл хурандаа М.Эрдэнэбаяр;

7. Шинжлэн магадлахуйн профессорын судалгааны багийн судлаач, доктор (Ph.D), цагдаагийн бэлтгэл хурандаа Б.Жаргалсайхан;

8. Гамшиг судлалын профессорын багийн профессор, доктор (Ph.D), бэлтгэл дэд хурандаа С.Базаррагчаа;

9. Удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага, стратегийн профессорын багийн профессор, доктор (Ph.D), хурандаа Ц.Бямбарагчаа;

10. Шинжлэн магадлахуйн институтын захирал, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа Б.Лхагвасүрэн.

Эрдмийн зөвлөлийн 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн Их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Б/339 дугаар тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн захирал, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа П.Батбаатарт “Их сургуулийн профессор” цол олгосон.

Эрдмийн дэд зөвлөл

Эрдмийн дэд зөвлөл 2020 онд 3 удаа хуралдаж, Хууль сахиулахын удирдлагын академийн болон Ахисан шатны боловсролын сургуулийн “Хууль сахиулахуйн удирдлага”, “Эдийн засгийн аюулгүй байдал”, “Мэдээллийн аюулгүй байдал”, “Хил судлал”, “Гэмт явдал судлал” хөтөлбөрөөр суралцаж буй 8 докторант, 11 магистрантын судалгааны ажлын сэдэв, удирдагч, харъяалах тэнхимийг хэлэлцэн батлав. Мөн “Эрх зүй” магистр, докторын хөтөлбөрийг хэлэлцэж, шинэчлэн батлуулахаар шийдвэрлэсэн.

Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/268 дугаар тушаалаар Дотоод хэргийн их сургуулийг түшиглэсэн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-д Хууль зүй, Хил судлал, Гамшиг судлал, Шинжлэн магадлахуй, Гүйцэтгэх ажил, Удирдахуйн ухааны 17 эрдэмтдийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан.

Дотоод хэргийн их сургуулийг түшиглэсэн “Докторын зэрэг хамгаалуулах” зөвлөл 2020 онд 13 удаа хуралдаж, докторантуудын диссертацийн ажлыг шүүн хэлэлцэж, 7 докторантад “Боловсролын доктор”-ын зэрэг олгов.

1. Докторант, Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа “Дээрэмдэх гэмт хэргийг гүйцэтгэх ажлаар илрүүлэх ажиллагааны онол, арга зүйн асуудал” сэдэвт диссертацийг амжилттай хамгаалж, Их сургуулийн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-ийн 2020 оны 02-р сарын 20-ны өдрийн хуралдааны шийдвэр, Эрдмийн зөвлөлийн 02/05 дугаар тогтоолоор “Хууль зүйн ухааны доктор”-ын зэрэг;

2. Докторант, Удирдлагын академийн Удирдахуйн ухааны профессорын багийн профессор, цагдаагийн хурандаа Д.Сундуйсүрэн “Хүн

барьцаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн асуудал” сэдэвт диссертацийг амжилттай хамгаалж, Их сургуулийн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-ийн 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрээр “Хууль зүйн ухааны доктор”-ын зэрэг;

3. Докторант, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн ахлах багш, М.Ванчигмаа “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэний нэхэмжлэл” сэдэвт диссертацийг амжилттай хамгаалж, Их сургуулийн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-ийн 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрээр “Хууль зүйн ухааны доктор”-ын зэрэг;

4. Докторант, Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, хурандаа В.Пүрэвбаасан “Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны аюулгүй байдлыг хангах арга зам” сэдэвт диссертацийг амжилттай хамгаалж, Их сургуулийн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-ийн 2020 оны 06 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрээр “Хил судлалын доктор”-ын зэрэг;

5. Докторант, Сити их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Б.Одонгэрэл “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдэвт диссертацийг амжилттай хамгаалж, Их сургуулийн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-ийн 2020 оны 06 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрээр “Хууль зүйн ухааны доктор”-ын зэрэг;

6. Докторант, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын төрийн цэргийн байгууллага хариуцсан ахлах референт Ч.Сайнтор “Хил хамгаалах байгууллагын хүний бодлого, хэрэгжүүлэх арга зам” сэдэвт диссертацийг амжилттай хамгаалж, “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-ийн 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрээр “Хил судлалын доктор”-ын зэрэг;

7. Докторант, Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Э.Идэрцог “Хүн амины хэргийн газрын үзлэгийн онол, практикийн асуудал” сэдэвт диссертацийг амжилттай хамгаалж, Их сургуулийн “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-ийн 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрээр “Хууль зүйн ухааны доктор”-ын зэрэг олгов.

Мөн докторант, Хил хамгаалах ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа А.Энхтөрийн “Монгол Улсын хилийн цэргийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудал”, докторант, Хилийн албаны сургуулийн ахлах багш, дэд хурандаа Х.Асхарын “Хилийн боомтын үйл ажиллагааг боловсронгуй болгох арга зам”, докторант, Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Б.Баянмөнхийн “Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалт” сэдэвт докторын зэрэг горилсон бүтээлийг шүүн хэлэлцэх урьдчилсан хамгаалалтыг 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан.



Профессорын судалгааны баг

Дотоод хэргийн их сургуулийн профессорын судалгааны багууд 2020 онд шинжлэх ухааны суурь болон хэрэглээний судалгаа хийх, туршилт боловсруулалтын ажил явуулах замаар шинэ мэдлэг бүтээх, үр дүнг сургалт, судалгааны эргэлтэд оруулах, практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, судалгаа, шинжилгээний ажил эрхэлж буй багш, судлаачдыг онол, арга зүйн мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллав.

Профессорын судалгааны багууд харьяалах тэнхимийн магистрант, докторантын судалгааны ажлын сэдэв, багш, судлаачдын нэг сэдэвт бүтээл, гарын авлага, эмхэтгэл, сурах бичгийн шаардлага, чанарын талаар болон магистрантын урьдчилсан хамгаалалт хийх зэрэг “Профессорын судалгааны багийн ажиллах журам”-аар зохицуулсан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан.


Их сургуулийн хэмжээнд нийт 18 чиглэлийн профессорын судалгааны баг ажиллаж, 52 удаа хуралдсан нь нэг судалгааны баг жилд дунджаар 3 удаа хуралдсан үзүүлэлттэй байна.

1. Удирдахуйн ухааны профессорын судалгааны баг- 3 удаа;
2. Эдийн засгийн аюулгүй байдал судлалын профессорын судалгааны баг- 3 удаа;
3. Гэмт явдал судлалын профессорын судалгааны баг- 4 удаа;
4. Гэмт хэрэг мөрдөхүйн ухааны профессорын судалгааны баг- 1 удаа;

5. Шинжлэн магадлахуйн ухааны профессорын судалгааны баг- 8 удаа;
6. Цагдаа судлалын профессорын судалгааны баг- 3 удаа;
7. Мэдээллийн аюулгүй байдал судлалын профессорын судалгааны баг;
8. Тагнах үйл ажиллагааны эрх зүй судлалын профессорын судалгааны баг;
9. Албаны бэлтгэл, тусгай тактик зүйн профессорын судалгааны баг- 3 удаа;
10. Замын хөдөлгөөний аюулгүй байдал судлалын профессорын судалгааны баг- 1 удаа;
11. Хил судлалын профессорын судалгааны баг- 9 удаа;
12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны баг- 4 удаа;
13. Гамшиг судлалын профессорын судалгааны баг- 4 удаа;
14. Нийгмийн ухааны профессорын судалгааны баг- 1 удаа;
15. Эрх зүйн ухааны профессорын судалгааны баг- 4 удаа;
16. Хууль сахиулахуйн боловсрол судлалын профессорын судалгааны баг;
17. Хэл шинжлэлийн ухааны профессорын судалгааны баг- 4 удаа;
18. Ахлагч мэргэжил судлал профессорын судалгааны баг- 3 удаа тус бүр хуралдсан байна.

Профессорын судалгааны багийн хуралдааны тоог графикаар харьцуулвал Хил судлалын судалгааны профессорын баг олон удаа хуралдсан байна.

График 1



Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн

Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн аюулгүй байдал, дотоод хэргийн салбарын шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгааг гүйцэтгэх, хууль зүйн салбарын инновацийн бодлогыг тодорхойлох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын онол, арга зүйн үндэслэл, үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, туршилт-судалгаа боловсруулалтын ажлыг эрхлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. Тайлант хугацаанд 52 ажлыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж 96,8 хувийн гүйцэтгэлтэйгээр биелүүлж, Их сургуулийн 2020 онд дэвшүүлсэн зорилтыг бүрэн ханган ажиллалаа.

Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн албан хаагчид 2020 онд бие дааж болон бүрэлдэхүүн сургууль, бүтцийн нэгжүүдтэй хамтран хийж гүйцэтгэсэн томоохон ажлууд, түүний ололттой талуудыг тоймлон авч үзвэл, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн болон ҮАБЗ-ийн ажлын алба, бусад байгууллагын захиалгаар 42 сэдвээр судалгааны ажил гүйцэтгэн үр дүнг захиалагч талд хүлээлгэн өгсөн.

Тухайлбал,

ХЗДХЯ-наас 2019 онд ирүүлсэн захиалгат дөрвөн багц судалгааны ажил болох Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлэх хүрээнд 12 судалгааны ажил, 77 дугаар тогтоолоор баталсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр” хэрэгжүүлэх хүрээнд 8 судалгааны ажил, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сургалт сурталчилгааны ажил”, “Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл боловсруулах” зэрэг ажлыг хийж гүйцэтгэн 2020 оны 02 дугаар сард тайлан, үр дүнг ХЗДХЯ-нд, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхлыг хангах асуудлаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанаас захиалсан 11 судалгааг хийж гүйцэтгэн амжилттай хэлэлцүүлж, 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр захиалагч байгууллагад тус тус хүлээлгэн өгсөн.

Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын захиалгаар “Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл”, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн захиалгаар “Улаанбаатар хотод аюулгүй байдлын зэрэглэл тогтоох, аюулгүй байдлын баталгаат загвар бүс бий болгох туршилт судалгаа”, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санхүүжилттэй “Монгол орны нэн ховор, ховор ургамлын хууль бус бэлтгэл, худалдааны өнөөгийн байдал, түүнийг илрүүлэх, таслан зогсоох боломж” зэрэг хавсарга болон хэрэглээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн.

Түүнчлэн, Их сургуулийн захирлын 2020 оны 02 дугаар сарын 27-ны А/37 дугаар тушаалаар Их сургуулийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайлан боловсруулан ажлын хэсэгт хүрээлэн, төвийн судлаачид оролцон тайланг боловсруулан ажиллав.

Ковид-19 цар тахлын улмаас Шинжлэх ухаан, технологийн сангийн дэмжлэгээр хэрэгжүүлж байгаа “Адууны туурай криминалистикийн адилтгал болон онош зүйн шинжилгээний объект болохыг тогтоох”, “Мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах криминалистикийн техник хэрэгслийг боловсронгуй болгох туршилт судалгаа”, “Хилийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчин суурь судалгаа”, “Ховор, нэн ховор ан амьтан хууль бусаар агнасан болон мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд митохондрийн ДНХ-ийн арга технологийг шүүхийн шинжилгээний практикт нэвтрүүлэх туршилт, судалгаа” сэдэвт төслийн санхүүжилтийг нэг жилээр хойшлуулсан боловч төслүүдийн судалгаа, туршилт-боловсруулалтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.

Олон улсын болон улс, салбарын хэмжээний нийт 8 удаагийн эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт боловсруулалтын ажлын санхүүжилтээр болон алба хаагчид дотоод нөөц бололцоогоо ашиглан ажлын байрны орчин нөхцөл, материаллаг баазыг сайжруулах томоохон ажлуудыг тайлангийн хугацаанд хийж гүйцэтгэлээ. Тухайлбал, “Судалгааны арга зүйн танхим” байгуулах, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн өрөөг тохижуулах, ажлын байрны коридорын ханыг засварлах, Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирлын өрөө болон Хууль сахиулахуйн боловсрол судлалын төвийн өрөөний засал, тавилга, ширээ сандлыг шинэчлэх, Инновацийн төвийн туршилт судалгааны лабораторид багаж, техник хэрэгсэл худалдан авах зэрэг. Засвар тохижилтын ажилд нийт 72,800,000 төгрөг зарцуулсан байна.



Түүнчлэн судалгааны ажлын санхүүжилтийг Их сургуулийн хөгжилд зориулж болохыг нотолсон жил боллоо. Тухайлбал, захиалгат судалгааны ажлын санхүүжилтээр Төв номын сан, спорт цогцолборын барилгын ажилд дэмжлэг үзүүлснийг дурдаж болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/132 дугаар тушаалаар ЭШНХ-ийн бүтэц, орон тоог шинэчлэн гурван төвийг нэмж байгуулснаар тус хүрээлэн нийт 10 нэгж, 32 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй болж өргөжсөн. Практик байгууллагаас 7 докторантыг шалгаруулж авснаар тус хүрээлэн 39 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. Их сургуулийн шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр Их сургуульд “шинжлэх ухааны цэрэг”-ийн нэгж байгуулан, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцуулах ажлыг санаачлан, зарим судалгааг хийж, санал боловсруулан холбогдох албан тушаалтанд танилцуулсан.



2020 онд хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр зарим арга хэмжээ авч ажилласныг дурдвал: 2020 оны 1 дүгээр сард цагдаагийн ахмад Г.Гантулгыг ШШҮХ-ээс, дэд хурандаа М.Ганбаатарыг ХХЕГ-аас шилжүүлэн томилуулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/132 дугаар тушаалаар ЭШНХ-ийн бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбоотойгоор ЭШНХ-ийн захирлаар доктор (Ph.D), цагдаагийн хурандаа Т.Очирбатыг, Инновацийн төвийн эрхлэгчээр хурандаа Б.Зулбадрахыг, Хууль сахиулахуйн боловсрол судлалын төвийн эрхлэгчээр доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа Б.Мөнхдоржийг, Хэвлэл, редакцийн хэлтсийн даргаар доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа Б.Цолмонг дэвшүүлэн томилсон ба Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн захирлаар хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, цагдаагийн бэлтгэл хурандаа Ж.Болдбаатар, Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнаар доктор (Ph.D), профессор, цагдаагийн бэлтгэл хурандаа Т.Оюунчимэг, Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн захирлаар доктор (Ph.D), профессор, бэлтгэл хурандаа А.Муратхан, Аюулгүй байдал судлалын төвийн

эрхлэгчээр Монгол Улсын гавъяат хуульч, цагдаагийн бэлтгэл хурандаа Д.Мөрөн, тус төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтнаар доктор (Ph.D), цагдаагийн хурандаа Н.Ганбадрал, Судлаачийн хөгжлийн төвийн судалгааны арга зүйч багшаар доктор (Ph.D), профессор, цагдаагийн бэлтгэл хурандаа Ч.Нямсүрэн, Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтнаар доктор (Ph.D), бэлтгэл хурандаа Ц.Ганболд, Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтнээр цагдаагийн дэслэгч С.Солонгыг томилсон.

Дотоод хэргийн их сургуулийн хотхоныг өргөжүүлэн хөгжүүлэх төсөөлөл боловсруулж, макет, танилцуулга хийлгэх ажилд ЭШНХ гол үүрэгтэй оролцсон. Улмаар ДХИС-ийн хотхоны төсөл, ТЭЗҮ хийлгэх ажлын даалгавар боловсруулах ажлыг зохион байгуулж байна. Их сургуулийн музейг нүүлгэн шилжүүлэх, шинэ үзмэрээр баяжуулах, Их сургууль, Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, бүрэлдэхүүн сургуулиудын үзмэрийн хэсгүүд дэх танилцуулга бэлтгэх ажилд идэвхтэй оролцлоо.



Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх төсөөлөл боловсруулж, макет хийлгэн, Их сургуулийн удирдлагын зүгээс санаачлагатай ажиллан

УИХ-ын дарга, Ерөнхий сайд, ХЗДХ-ийн сайд, БШУ-ны сайд, холбогдох бусад албан тушаалтнуудад танилцуулан, түүний ТЭЗҮ-г хийлгэхээр шийдвэрлүүлсэн нь Их сургууль цаашид аюулгүй байдал, дотоод хэргийн салбарын шинжлэх ухаан, технологийн томоохон төв, технополис хотхон болж хөгжих материаллаг орчин бүрдэх алхам болж байна. Энэ том төслийн нэг хэсэг нь Их сургуулийн шинжлэх ухаан, инновацийн төв (кластер) байгуулах төсөл юм. Шинжлэх ухаан, инновацийн төв байгуулах төсөл хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл Монгол Улсын хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” болон бусад холбогдох баримт бичгүүдэд тодорхой туссан нь уг төсөл хэрэгжих бодит нөхцлийн нэг юм. Түүнчлэн, Их сургуулийн стратеги төлөвлөгөөнд энэ заалтыг үндэслэн “Дотоод хэргийн их сургуулийн шинжлэх ухаан, инновацийн хөгжлийн хөтөлбөр 2021-2024” боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгасан ба уг хөтөлбөрийн төслийг боловсруулж бэлэн болголоо.

СУДАЛГАА-БОЛОВСРУУЛАЛТЫН ХҮНИЙ НӨӨЦ

Дотоод хэргийн их сургуульд нийт 500 гаруй албан хаагч ажиллаж байгаа бөгөөд докторын зэрэгтэй 54 эрдэмтэн, судлаач байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/132 дугаар тушаалаар Дотоод хэргийн их сургуулийн бүтэц, дүрмийг баталснаар Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн бүтэц шинэчлэгдсэн. Үүнд:

- Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэн;
- Хилийн аюулгүй байдал, судлалын хүрээлэн;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв;
- Шинжлэн магадлахуй судлалын төв;
- Гамшиг судлалын төв;
- Инновацийн төв;
- Аюулгүй байдал судлалын төв;
- Хууль сахиулахуйн боловсрол судлалын төв;
- Судлаачийн хөгжлийн төв

• Хэвлэл, редакцийн хэлтэс гэсэн зохион байгуулалттай, орон тооны хувьд Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал-1, Салбар хүрээлэнгийн захирал-2, Эрхлэгч-6, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан-6, Эрдэм шинжилгээний ажилтан-8, Эрдэм шинжилгээний туслах ажилтан-2, Эрдэм шинжилгээний мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн-1, Эрдэм шинжилгээний ажлын төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн-1, Хэвлэл, редакцийн хэлтсийн дарга бөгөөд ахлах редактор-1, Хэвлэлийн редактор-1, Хэвлэлийн эх бэлтгэгч-дизайнер-1, Хэвлэгч, зураг авагч-1, Дэвтэрлэгч-1 гэсэн нийт 32 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллав.

Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн бүрэлдэхүүнд шинжлэх ухааны доктор 1, боловсролын доктор 11, магистр зэрэгтэй судлаач 16 байна.

Их сургуулийн хэмжээнд багшлах бүрэлдэхүүн 186 байгаагаас докторын зэрэгтэй 54 байгаа нь нийт багшлах бүрэлдэхүүний 29,3 хувийг эзэлж байна.

Их сургуулийн хэмжээнд ажиллаж байгаа эрдэмтэн, профессор судлаачдаас 2020 оны “Тэргүүний эрдэм шинжилгээний ажилтан”-аар Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хууль сахиулахуйн боловсрол судлалын төвийн эрхлэгч, доктор, цагдаагийн дэд хурандаа Б.Мөнхдорж, “Тэргүүний судлаач багш”-аар Чанарын баталгаажуулалтын төвийн хөтөлбөрийн чанар, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн, доктор, дэслэгч Ц.Баясгалан “Тэргүүний залуу судлаач”-аар Цагдаагийн сургуулийн дэд захирал, цагдаагийн хошууч Г.Мөнгөншагай нар шалгаран эрдэм шинжилгээ, судалгааны ажлаараа хамт олноо манлайлан ажиллалаа.

СУДАЛГАА-БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ

Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилттэй төсөл, хэрэгжилт

1. АДУУНЫ ТУУРАЙ КРИМИНАЛИСТИКИЙН АДИЛТГАЛ БОЛОН ОНОШ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ОБЪЕКТ БОЛОХЫГ ТОГТООХ СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСӨЛ

• ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА: 2018-2020

Удирдагч:

Хууль зүйн ухааны доктор (Ph.D) Б.Цолмон

Захиалагч (дэвшүүлэгч):

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Гүйцэтгэгч:

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн

Судалгааны ажлын зорилго:

Адууны туурайны эвэрлэг ханын гадаргуу дээрх зураасан шугамууд нь хүний гарын хурууны папилляр хээ болон хумсны ялтас дээрх ховил, атриа, нарийн сувагтай адил хувийн, тогтвортой, дахин давтагдашгүй шинж чанарыг агуулж байгаа эсэхийг криминалистикийн шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан шинжлэн судалсны үндсэн дээр, тэдгээрийг криминалистикийн адилтгалын /идентификацийн/ ба онош зүй шинжилгээнд ашиглах боломжтой эсэхийг тогтоож, үндэслэл бүхий дүгнэлт, зөвлөмж, гарын авлага гаргахад, уг суурь судалгааны төслийн зорилго оршино.

Зорилт:

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тодорхойлов. Үүнд:

1. Судалгааны төсөл хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж, бэлтгэл ажлыг хангах;
2. Адууны туурай цуглуулах, зүс болон онцлог шинж тэмдгийг гэрэл зургийн аргаар бэхжүүлэх, адууны дэл, сүүлний үснээс дээж авч, тэдгээрийг битүүмжилж, хүргүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;
3. Туршилт, шинжилгээ, судалгаа явуулах орчин нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай багаж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон программ хангамжийг суурилуулах;
4. Адууны туурайг лабораторийн нөхцөлд шинжилж судлах, туршилт хийх ажлыг зохион байгуулах;
5. Судалгаа төслийн ажлын үр дүнг тооцож, тайлагнах.

**2.МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ
КРИМИНАЛИСТИКИЙН ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ТУРШИЛТ СУДАЛГАА
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТӨСӨЛ**

• ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА: 2019-2020

Удирдагч:

Т.Очирбат

Захиалагч (дэвшүүлэгч):

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Гүйцэтгэгч:

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн

Судалгааны ажлын зорилго:

Монгол орны орчин нөхцөл /байгаль цаг уур, амьдах хэв маяг, эрх зүйн орчин, хуулийн байгууллагын тогтолцоо/-д тохирсон техник хэрэгслийн иж бүрдлийг судалгаанд үндэслэн үйлдвэрлэх, угсрах, бүрдүүлэхэд орших бөгөөд төслийн үр дүнд гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах криминалистикийн техник хэрэгслийн иж бүрдэл бий болох юм.

Төслийн хүрээнд:

1. Хэргийн газрын үзлэгт ашиглах криминалистикийн 3 төрлийн иж бүрдэл цүнх,

2. “Криминалистикийн техник хэрэгслийн хангамж”, “Криминалистикийн техник хэрэгслийн ашиглалтын өнөөгийн байдал” судалгааны тайлан,

3. “Хэргийн газарт мөртэй ажиллах арга зүй” сурах бичиг зэргийг хийж гүйцэтгээд байна.

**3.ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН
СУУРЬ СУДАЛГАА**

СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСӨЛ

• ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА: 2019-2020

Удирдагч:

Ш.Лхачинжав

Захиалагч (дэвшүүлэгч):

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

Гүйцэтгэгч:

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн

Судалгааны ажлын зорилго:

Энэхүү төслийн зорилго нь хилийн аюулгүй байдлын онол, арга хэлбэр, чиг хандлага, гадаад, дотоод хүчин зүйлүүдийн нөлөөллийг тодорхойлох, өнөөгийн эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, сайжруулах, хилийн аюулгүй байдлыг хангахад дэвшилтэд техник, технологийн инновацийг нэвтрүүлэх туршилт, судалгаа, шинжилгээ хийхэд оршино.

Төслийн хүрээнд:

“Хилийн аюулгүй байдлын онолын үндэс”, “Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах арга замыг боловсронгуй болгох нь”, “Монгол Улсын төрөөс хилийн аюулгүй байдлыг хангах талаар баримталж ирсэн бодлого, түүхэн уламжлал, шинэчлэл, тогтолцоо”, “Хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын баталгаа болох нь”, “Аюулгүй байдлын нэр томьёо, түүний тайлбар, зүйлчлэл” зэрэг судалгааны ажил хийж гүйцэтгээд байна.

4.ХОВОР, НЭН ХОВОР АН АМЬТАН ХУУЛЬ БУСААР АГНАСАН БОЛОН МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД МИТОХОНДРИЙН ДНХ-ИЙН АРГА ТЕХНОЛОГИЙГ ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ПРАКТИКТ НЭВТРҮҮЛЭХ ТУРШИЛТ, СУДАЛГАА”

ЗАХИАЛГАТ СУДАЛГААНЫ ТӨСӨЛ

• ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА: 2020-2022

Удирдагч:

Д.Баярлхагва

Захиалагч (дэвшүүлэгч):

Хууль зүй, дотоод хэргийн яам

Гүйцэтгэгч:

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Монгол Улсын их сургууль

Судалгааны зорилго:

Гэмт хэрэг, зөрчлийн хэрэгт ан амьтны гаралтай түүхий эдийн зүйлийн харъяалалыг Scientific Working Group on DNA Analysis Methods /(SWGDM)/-ийн зөвлөмжид тулгуурлан митохондрийн ДНХ-ийн шинжилгээгээр тогтоох аргачлалыг боловсруулах, Митохондрийн ДНХ-ийн шинжилгээний арга технологийг ашиглан туршилт судалгаа хийж, үр дүнг шүүхийн шинжилгээнд нэвтрүүлэхэд оршино.

Төслийн хүрээнд:

1. Ховор, нэн ховор ан амьтны дээжийг цуглуулж бэлтгэсэн.
2. Мал амьтны дээжнээс митохондрийн болон геномын ДНХ ялган, цуглуулга хийж, ПГУ-ын праймер сонгох, туршилт явуулсан.

Захиалгат болон төлөвлөгөөт судалгаа-боловсруулалтын ажил

Аюулгүй байдлыг хангах, дотоод хэргийн салбарын тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэж, судалгааны тайлан, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллав. Тайлант хугацаанд давхардсан тоогоор¹ 75 судалгааны ажил гүйцэтгэжээ.

№	Захиалгат/ төлөвлөгөөт	Судалгааны ажлын нэр	Судалгааны ажлын гүйцэтгэл	Судалгааг гүйцэтгэгч
Эрдэм шинжилэний нэгдсэн хүрээлэн				
1.	ХЗДХЯ-ны ГХУСАЗЗ-ийн Ажлын албаны захиалгат	Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд хийсэн судалгаа	“Хүн худалдаалах гэмт хэрэг, түүний хор уршиг”	
2.			“Гэмт хэрэгт өртөж байгаа болон хөдөлмөрийн мөлжлөгт өртөж байгаа хүүхэд”	
3.			“Бэлгийн мөлжлөгт өртөж болзошгүй газруудын судалгаа”	
4.			“Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх”	
5.	ХЗДХЯ-ны ГХУСАЗЗ-ийн Ажлын албаны захиалгат	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх зарим судалгааны ажил	“Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодистой холбоотой гэмт хэрэгт ногдуулах хариуцлагын асуудлыг ялгамжтай байдлаар тогтоох, хэргийн хүндрүүлэх болон хөнгөрүүлэх нөхцөл байдал”	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн
6.			“Хүүхэд, өсвөр насныхны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист автах эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”	
7.			“Гэр бүл, сургууль, ажлын байрны болон хэвлэл мэдээллийн чиглэлээр урьдчилан	

¹ Зарим судалгааг ЭШНХ, Бүрэлдэхүүн сургууль, бүтцийн нэгжийн судлаач, багш, албан хаагчид хамтран гүйцэтгэсэн.

			сэргийлэх сургалтын хөтөлбөр, холбогдох сургалт сурталчилгаа”		
8.			“Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн эрсдэлийн үнэлгээ”		
9.			“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм, бодис, мансууруулах үйлчилгээтэй ургамлыг ялгах, сэжигтэй хүнийг таньж олох”		
10.	ХЗДХЯ-ны ГХУСАЗЗ-ийн Ажлын албаны захиалгат	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн судалгаа, сургалт, сурталчилгаа			
11.	ХЗДХЯ-ны ГХУСАЗЗ-ийн Ажлын албаны захиалгат	“Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл боловсруулах”			
12.	БЗД-ийн ИТХ, ГХУСАЗСЗ-ийн захиалгат	“Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн криминологи судалгаа”	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн	ЭШНХ, Бүрэлдэхүүн сургуулиудын холбогдох судлаач нар “Судлаач хуульчдыг дэмжих эрдэмтэн сан”	
13.	БЗД-ийн ГХУСАЗСЗ-ийн захиалгат	“Баянзүрх дүүргийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох”	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн	ЭШНХ-ийн Шинжлэн магадлахуй судлалын төв	
14.	Нээлттэй нийгэм форумын захиалгат	“Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалын хэрэглээ”	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн	ЭШНХ-ийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэн	
15.	ГХУСАЗЗ-ийн Ажлын алба, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын захиалгат	“Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт явдалтай тэмцэхэд мэдээллийн нэгдмэл байдал, уялдааг хангах асуудал”	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн		

16.	Нээлттэй нийгэм форумын захиалгат	“Цагдаагийн алба хаагчдын ажил дүгнэх үзүүлэлт хүний эрхийн зарчимд нийцсэн эсэх”	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн	
17.	СХД-ийн ИТХ-ын захиалгат	“Сонгинохайрхан дүүргийн хэмжээн дэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал” криминологи судалгаа	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн	
18.	ЦЕГ-ын захиалгат	“Цагдаагийн байгууллагын объектын судалгааны өнөөгийн байдал арга зүй” SWOT шинжилгээ	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн	
19.	ХЗДХЯ-ны захиалгат	“Улаанбаатар хотод аюулгүй байдлын зэрэглэл тогтоох, аюулгүй байдлын баталгаат загвар бүс бий болгох туршилт судалгаа” тойм судалгаа	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн	ЭШНХ-ийн Инновацийн төв
20.	ШШГЕГ-ын захиалгат	“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжилт”	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн	ЭШНХ-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төв
21.		“Иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт”		
22.		“Хоригдогсдын өөр хоорондоо харилцах зүй бус, этгээд хэллэгийн хэлбэр, онцлог ба түүний уламжлалт болон орчин үеийн нөхцөлд хийх дүн шинжилгээ”		
23.		“Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг сургалт- хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт”		
24.		“Хорих байгууллагад явуулж буй нийгэмшүүлэх ажилд хийсэн шинжилгээ /2015-2020/”		
25.		“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, төсөөлөл”		
26.	ШШГЕГ-ын Баривчлах төвийн захиалгат	“Баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ”	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн	
27.	ШШГЕГ-ын Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны захиалгат	“Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох зарим асуудал”	Судалгааны ажлыг гүйцэтгэн, үр дүнг хүлээлгэн өгсөн	

28.	ГХУСА33-ийн Ажлын алба, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран	“Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам”	Судалгааны ажлыг ЦЕГ-тай хамтран гүйцэтгэсэн.	ЭШНХ, Бүрэлдэхүү н сургуулиуд ын холбогдох судлаач нар
29.	“Хилийн аюулгүй байдлын онол, түүний үндэс” ХЗДХЯ-ны захиалгат төслийн хүрээнд	“Аюулгүй байдлын нэр томьёо, түүний тайлбар, зүйлчлэл”	Дэд тайланг боловсруулж дууссан.	ЭШНХ-ийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэн
30.	Нэгжийн төлөвлөгөөнд тусгагдсан	“Объектын түймрийн эрсдэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, үүссэн шалтгаан нөхцөл” /БЗД-ийн жишээн дээр/	Судалгааг гүйцэтгэж, хэвлүүлсэн.	ЭШНХ-ийн Гамшиг судлалын төв
31.	ажил	“Газар хөдлөлтийн идэвхжил, бэлэн байдлыг хангах”		
32.	ҮАБЗ-ийн Ажлын албаны захиалгат	“Олон улсын хууль тогтоомж, гэрээ конвенцид гарч буй өөрчлөлт”	Судалгааны ажлыг гүйцэтгэж, ҮАБЗ-ийн Ажлын албанд хүлээлгэн өгсөн.	ЭШНХ, Бүрэлдэхүү н сургуулиуд ын холбогдох судлаач нар
33.		“Цэргийн анги байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, ноцтой зөрчил”		
34.		“Монгол Улсын хилийн аюулгүй байдлын нөхцөл байдал”		
35.		“Боомтууд дээр үүсэж буй зөрчил, тулгамдаж буй зарим асуудал, шийдвэрлэх арга зам”		
36.		“Хил орчмын бүс нутгийн эдийн засгийн хөгжил, хил дагуух орон нутгийн хөгжлийн бодлого”		
37.		“Хүүхэд залуучуудын хүмүүжил, сэтгэхүйн доройтол ба гаднын соёлын дам нөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернэт орчны хор уршиг”		
38.		“Цахим мөнгөний олон улсын зах зээл, түүнтэй холбоотой болзошгүй эрсдэлүүд, баримтлах стратегийн”		
39.		“Хууль хэрэгжүүлэх, сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагааны хамтарсан хороо байгуулах тухай МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл”		
40.		“Төрийн бодлогын залгамж чанар, нэгдмэл байдал”		
41.		“Гадаад орнуудад Монгол Улсын иргэн гэмт халдлагад өртсөн, сураггүй болсон, гадаадад орнуудад буй манай иргэдээс		

		үйлдсэн гэмт хэрэг, шүүхээр шийдвэрлэсэн болон ял эдэлж байгаа тухай”		
42.		“Үндэстэн дамнасан гэмт хэрэг, дүрвэгсэд, хууль бус цагаачлал, терроризм, хүний наймаа, мансууруулах бодистой хийх тэмцэл”		
Сургалтын бодлого, төлөвлөлтийн газар				
43.	Нэгжийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил	“ДХИС-ийн “Төгсөгчдийн замнал тодоорхойлох, төгсөгчийн манлайлал, карьер эрхлэлтэд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа”	2020	Цагдаагийн ахлах дэслэгч Д.Баттөр
Цагдаагийн сургууль				
44.	Монгол Улсын ҮАБЗ-ийн Ажлын албаны захиалгат	“Цахим мөнгөний олон улсын зах зээл, түүнтэй холбоотой болзошгүй эрсдэлүүд, баримтлах стратеги, “Мансууруулах бодистой хийх тэмцэл”, “Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй хийх тэмцэл”	2020	Цагдаагийн хошууч А.Лхамсүрэн, цагдаагийн хошууч Б.Эрдэнэбат, В.Амарсанаа, цагдаагийн ахлах дэслэгч Э.Түвшин-Эрдэнэ
45.	Улсын Мөрдөн байцаах газрын Тусгай субьектын үйлдсэн гэмт хэргийг шалгах хэлтсийн захиалгат	“Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал”	2020	Цагдаагийн хошууч Б.Энхболд, цагдаагийн дэд хурандаа С.Гантулга, ахлах багш, доктор, цагдаагийн дэд хурандаа Л.Бат-Очир нар
Ахисан шатны боловсролын сургууль				
46.	ҮАБЗ-ийн Ажлын албаны захиалгат	“Хил орчмын бүс нутгийн эдийн засгийн хөгжил, хил дагуух орон нутгийн хөгжлийн бодлого”	2020 оны 9 сар	Дэд хурандаа М.Баярсайхан
47.	Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилттэй “Хилийн аюулгүй байдлыг хангах онол, арга зүйн үндэс” төсөл	“Монгол Улсын хууль эрх зүйн баримт бичигт хилийн аюулгүй байдлын талаар тусгагдсан заалт, түүнийг боловсронгуй болгох арга зам”	2020	Доктор (Ph.D), дэд профессор, хурандаа В.Жавхланцогт дэд хурандаа М.Баярсайхан
48.	“Хилийн аюулгүй байдлын онол арга зүйн үндэс” төсөл	“Хилийн аюулгүй байдлын онол арга зүйн үндэс”		Доктор (Ph.D), профессор А.Муратхан

				дэд хурандаа М.Баярсайхан
Удирдлагын академи				
49.	“Дотоод хэргийн их сургуулийн тухай хуулийн төсөл” боловсруулах төлөвлөгөөт судалгааны ажил	“Төрийн тусгай албан хаагчийн болон ДХИС-ийн алба хаагчидын эрх зүйн байдалд хийсэн дүн шинжилгээ”	Судалгааны тайланг 2020 оны 05 сарын 25-ны өдөр ажлын хэсгийн ахлагчид хүлээлгэж өгсөн.	Доктор (Ph.D), дэд профессор цагдаагийн хурандаа Б.Одбаатар
50.		“ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, ИБУИНВУ болон Европын холбооны тэргүүлэх улс, бусад хөгжингүй улсын ижил төстэй байгууллагын үйл ажиллагааны тухай хууль тогтоомжийн судалгаа”		Доктор (Ph.D), дэд профессор цагдаагийн дэд хурандаа Г.Базарваань
51.		“Сургалтын түшиц байгууллагатай холбогдох хуулийн заалтыг боловсруулах”		Доктор (Ph.D), дэд профессор профессор, дэд хурандаа Г.Лхагвамаа
52.	Монгол Улсын ҮАБЗ-ийн захиалгаар Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтарсан	“Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын өнөөгийн байдал”	Судалгааны тайлан боловсруулсан	Г.Базарваань Г.Лхагвамаа
Хилийн албаны сургууль				
53.	“Дотоод хэргийн их сургуулийн тухай хуулийн төсөл” боловсруулах төлөвлөгөөт судалгааны ажил	Дотоод хэргийн их сургуулийн бие бүрэлдэхүүний эрх зүйн байдал, цэргийн албаны зохион байгуулалттай холбоотой Монгол улсын хууль тогтоомжийг судалж, хуулийн төсөлд тусгах хэм хэмжээг томъёолох	Судалгаа хийж, үр дүнг танилцуулж ажилласан.	Хурандаа Д.Мөнгөнжин , Дэд хурандаа Л.Мандах, Хошууч Ч.Мягмарбаяр
54.	ҮАБЗ-ийн Ажлын албаны захиалгат судалгаа	“Хилийн аюулгүй байдлыг хангахад хил хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, түүнд хийсэн дүн шинжилгээ”	Судалгаа хийж, үр дүнг танилцуулж, ажлын хэсэгт ажилласан.	Дэд хурандаа Ч.Чулуунхүү, Дэд хурандаа Б.Мөнгөнбагана
55.		“Цэргийн анги байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, ноцтой зөрчил”		Хошууч Д.Энхтайван
56.		“Хил орчмын бүс нутгийн эдийн засгийн хөгжил, хил дагуух орон нутгийн хөгжлийн бодлого”		Хошууч Л.Лхагвасүрэн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургууль				

57.	ХЗДХЯ-ны захиалгат	“Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах”	2020	Доктор (Ph.D), Б.Галбадрах
58.		“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх/ хэрэгжилтийн үр дагавар”		Хошууч Г.Хосбаяр,
59.		“Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн орчинг бий болгох хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах”		Ахмад Э.Өнөболд
60.	Нэгжийн төлөвлөгөөнд тусгасан ажил	“Шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын хэрэгцээ шаардлагыг тандан судлах”,	2020	Ахлах дэслэгч Ю.Оюунаа
61.		“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн /иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа/-ны хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх”,		
62.		“Иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг гадаад улсын иргэний шийдвэр гүйцэтгэх тухай хуультай харьцуулан судлах”		
Онцгой байдлын сургууль				
63.	ҮАБЗ-ийн Ажлын албаны захиалгат	“Хүүхэд залуучуудын хүмүүжил, сэтгэхүйн доройтол ба гадны соёлын дам нөлөө, интернэт орчны хор уршиг”	Тайлан боловсруулж, ажлын хэсгийн ахлагчид хүлээлгэн өгсөн.	Доктор (Ph.D), Ц.Баясгалан З.Даваасүрэн Б.Энхтүвшин Л.Булганханга й Ц.Ганчимэг Г.Хатанбаатар Г.Чулуунбаата р Б.Батцэцэг Н.Одмаа
Эрх зүй, нийгмийн ухааны сургууль				
64.	БЗД-ийн ИТХ, ГХУСАЗСЗ, ЦЕГ-ын захиалгат	“Баянзүрх дүүргийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох криминологи судалгаа”	Судалгааны тайланг 2020 оны 02-р сарын 7-ны өдөр захиалагчид хүлээлгэн өгөв.	Цагдаагийн хошууч Д.Бадамцэцэг, Цагдаагийн дэслэгч К.Ариунзул
65.	ХЗДХЯ-ны захиалгат	“Хилийн аюулгүй байдал, түүний онол, арга зүйн үндэс”	Судалгааны ажлыг гүйцэтгэж захиалагчид хүргүүлсэн.	Доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Н.Мөнхзул, цагдаагийн хошууч Д.Бадамцэцэг,

				цагдаагийн ахлах дэслэгч Д.Энх-Амар нар
66.		“Дүрвэгч, цагаачдын гэмт хэрэг”		Доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа Ж.Нямдулам, цагдаагийн дэслэгч К.Ариунзул нар
67.	ҮАБЗ-ийн Ажлын албаны захиалгат	“Хууль хэрэгжүүлэх, сахиулах байгууллага хоорондын хамтын ажиллагааны хамтарсан хороо байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөл”	Тайланг ажлын хэсгийн ахлагчид хүлээлгэн өгсөн.	Доктор (Ph.D), цагдаагийн хурандаа Ш.Ариунбилэ г, цагдаагийн ахмад О.Отгонтуяа, цагдаагийн дэслэгч Б.Хулан, дэслэгч Н.Өнөржарга л, цагдаагийн дэслэгч А.Уянга
68.		“Дүрвэгсэд, хууль бус цагаачлалын хэрэгтэй хийх тэмцэл” сэдэвт судалгааны ажил		Ахмад Ж.Ууганчимэг Ахмад Г.Батжаргал, Ахлах дэслэгч Э.Хишигбайгал ь
69.		“Монгол улсын эрх зүйн тогтолцоо, түүний хөгжлийн бодлого, стратегийн үнэлгээ”, “Эрх зүй мэргэжил олгох сургалтын үнэлгээний зохион байгуулалтын онцлог, өнөөгийн байдал”		Доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа Н.Мөнхзул, цагдаагийн ахлах дэслэгч Э.Чимидлхам
70.	Боловсролын магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлын хүрээнд	“Эрх зүйч мэргэжлээр төгссөн төгсөгчдийн өрсөлдөх түвшин туршлага сургамжид үнэлгээ хийх”, “ДХИС судалгааны байгууллагатай хамтран ажиллах боломжид судалгаа хийж үнэлэлт өгөх”, “МУ-ын хөгжлийн стратегийг тодорхойлж байгаа баримт бичигт эрх зүйч мэргэжилтэнд тавигдаж буй шаардлага уялдаа холбол өнөөгийн байдалд үнэлгээ хийх”	Судалгааны ажлыг хийж хүлээлгэн өгсөн.	Доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн дэд хурандаа Ж.Нямдулам, Цагдаагийн ахлах дэслэгч Э.Чимидлхам, Дэслэгч К.Ариунзул

71.		“Эрх зүй” мэргэжлээр бакалаврын боловсрол олгох сургалтын хөтөлбөр, технологийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох арга замыг тодорхойлох нь” “Дотоодын болон гадаад орнуудын “Эрх зүй” мэргэжил олгох сургалтын хөтөлбөр, технологийн агуулгад харьцуулсан судалгаа хийх”		Цагдаагийн хошууч Д.Бадамцэцэг, ахлах дэслэгч Д.Энх-Амар
